

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 08 дугаар
сарын 30 -ны өдөр

Дугаар А/1/245
333

Улаанбаатар хот

Ундны болон ахуйн усны хоногт шаардагдах
зохистой хэмжээг батлах тухай

Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Монгол хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах Ундны усны хоногт шаардагдах зохистой хэмжээг нэгдүгээр, Ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар/Ш.Мягмар/-т тус тус даалгасугай.



Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин,
аялал жуулчлалын сайдын
2017 оны 08 сарын 30-ны өдрийн
1/203 1/2145 дугаар хамтарсан
тушаалын 1 дүгээр хавсралт

Ундны усны хоногт шаардагдах зохистой хэмжээ

Хүн амын бүлэг			Биеийн жингийн дундаж, кг	Ундны усны хоногт шаардагдах зохистой хэмжээ, мл/хоног	Баримжаалсан хэмжээ, аяга (нэг аяга=200мл)
Амьдралын мөчлөг	Нас	Хүйс			
Нялх хүүхэд	7-12 сар	Эр	10	300	1.5
		Эм	10	300	1.5
Хүүхэд, өсвөр нас	1-3 нас	Эр	13	390	2
		Эм	12	360	2
	4-6 нас	Эр	20	600	3
		Эм	19	570	3
	7-10 нас	Эр	28	840	4
		Эм	29	870	4
	11-14 нас	Эр	45	1350	7
		Эм	46	1380	7
	15-17.9 нас	Эр	60	1800	9
		Эм	52	1560	8
Насанд хүрэгчид (Биеийн хүчний хөнгөн хөдөлмөр эрхлэгч)	18-29.9 нас	Эр	60	3042	15
		Эм	52	2184	11
	30-59.9 нас	Эр	59	2991	15
		Эм	51	2142	11
Настан	≥60 нас	Эр	55	1650	8
		Эм	53	1590	8
Жирэмсэн эмэгтэй			64	2220	11
Хөхүүл эх			52	2260	11
Биеийн хүчний дунд зэргийн ачаалалтай хөдөлмөр эрхлэгч	18-59.9 нас	Эр	60	3582	18
	18-54.9 нас	Эм	52	2652	13
Биеийн хүчний хүнд хөдөлмөр эрхлэгч	18-59.9 нас	Эр	60	4320	22
	18-54.9 нас	Эм	52	3120	16

Тайлбар:

- Нялх хүүхэд болон хүүхэд, өсвөр насны хүүхдийн биеийн жингийн дундаж хэмжээг "Биеийн жингийн лавлагаа дундаж хэмжээ (ДЭМБ, 2006)"-д үндэслэв.
- Насанд хүрэгч, настаны биеийн жингийн дундаж үзүүлэлтийг "Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа (2013)"-ны мэдээлэлд үндэслэв.
- Ундны усны хоногт шаардагдах зохистой хэмжээг НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас баталсан "Хүний илчлэгийн хэрэгцээ"-г тогтоох аргачлалд үндэслэн тооцов.



Ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээ

Ус хангамжийн төрөл			Ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээ, (хүн/хоног/литр)
I.Төвлөрсөн ус хангамж			
Нийт хэмжээ (хүн/хоног/литр)			200
Үүнээс:	Хоол хүнс бэлтгэх, сав суулга угаах		30
	Хувийн ариун цэвэр сахих	Шүд, нүүр, гар угаах	8
		Усанд орох (шүршүүрт)	55
	Угаалга, цэвэрлэгээ		67
	Ариун цэврийн байгууламж-суултуур		40
II. Төвлөрсөн бус ус хангамж			
Нийт хэмжээ (хүн/хоног/литр)			50
Үүнээс:	Хоол хүнс бэлтгэх, сав суулга угаах		14
	Хувийн ариун цэвэр сахих	Шүд, нүүр, гар угаах	8
		Усанд орох (бие угаах)	17
	Угаалга, цэвэрлэгээ		11

----oOo----